

*Үндэсний зөвлөлийн 2008 оны 1 дүгээр сарын 30-ны
өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлав.*

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үргэлжлүүлэн
хэрэгжүүлэх 2008 оны ажлын төлөвлөгөө**

I. Зорилго: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (цаашид “ОУИТБС” гэх)-ын зохион байгуулалт, бүтэц, 3 талын оролцогчдын мэдлэг, ур чадвар, чадавхи бий болгон санаачлагыг үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх явдал мөн.

II. Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хугацаа, эзэн, зардал:

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Зардал
I Үе шат- Санаачлагад элсэн орох					
1	Засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа талаар нийтэд хандсан уриалга, мэдээлэл хийх	-санаачлагын тайланд аудит хийсэн дүн, цаашдын зорилтын талаар Үндэсний зөвлөлийн мэдээлэл гаргах	-2008 оны 2 дугаар сар	ҮЗ-ийн нарийн бичгийн дарга Ажлын алба	Зардал ЗГХЭГ хариуцна
2	Хандивлагч орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах	-Аудитын тайлан, 2008 онд зохиох ажлын төлөвлөгөө, төсвийн талаар ОУИТБС-ын Удирдах зөвлөл, Дэлхийн банкинд хүсэлт явуулах, тохиролцох -Ажлын төлөвлөгөө болон Хандивлагчдын Итгэлийн сангийн тусламжийг хэрхэн зохицуулах чиглэлээр дэлхийн банкны ажилтнуудтай мэдээлэл солилцох -Бусад олон улсын хандивлагч, бусад оронтой хамтран ажиллах талаар санал тавих	2008 оны 1-3 дугаар сард	Ажлын албаны зохицуулагч	Ажлын албаны өдөр тутмын зардлаар
II үе шат Бэлтгэл хангах					
А. Зохион байгуулалтын талаар					
3	Улсын Их Хурлын Эдийн засаг болон Төсвийн Байнгын хороо болон Засгийн газрын гишүүдэд ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, үр дүн, цаашид авах арга хэмжээг танилцуулж шийдвэрлэх	-Санаачлагын үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлээр мэдээлэл бэлтгэж УИХ-ын холбогдох байнгын хороодод танилцуулга хүргүүлэх	2008 оны 2 дугаар сард	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг	Зардал Засгийн газрын өдөр тутмын зардал
		-Засгийн газрын хуралдаанд ОУИТБС-ын үр дүн, цаашдын үйл ажиллагааны талаар танилцуулах	Шаардлага гарсан үед	-ҮЗ-ийн дарга -Ажлын хэсгийн ахлагч	Зардал Засгийн газар хариуцна.
4	Үндэсний зөвлөл болон ажлын хэсгийн хурлыг хийж цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн шийдвэрлэж байх	-Ажлын хэсгийн хурлаар дараахь асуудлыг хэлэлцүүлэх: -Аудитын дүн -2008 хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл -Тайлан гаргах маягт, зааврын тухай -Тайлан гаргахад бэлтгэх -Аудит хийх бэлтгэл ажил г.м	2 сард 1 удаа	-Ажлын хэсгийн ахлагч -Ажлын хэсгийн нбд -Ажлын албаны зохицуулагч	Зардал ЗГ хариуцна.
		-Үндэсний зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангаж, хурал зохион байгуулах: -Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж гишүүдийн санал тусгасан асуудлыг хэлэлцүүлж батлуулах, дэмжлэг авах -Шаардлагатай бусад асуудал	Хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа	-ҮЗ дарга -ҮЗ нарийн бичгийн дарга -Ажлын албаны зохицуулагч	Зардал ЗГ хариуцна

5	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн удирдлагуудтай уулзаж ярилцах, санал солилцох	-График гарган явж ярилцах -Ярилцлагын дүнг танилцуулж ажлын хэсэг ярилцах	2008 оны 2-3 дугаар сараас	-Ажлын алба -УУА гүйцэтгэх захирал -Гишүүд	Засгийн газар, ажлын албаны өдөр тутмын зардал
6	ОУИТБС-ыг хэрэгжүүлэхтэй холбогдон нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах хууль тогтоомжийн талаар судалгаа хийх, төсөл боловсруулах	-Хууль тогтоомжийн судалгаа хийх -Хуулийн төсөл боловсруулах	2008 он	-ҮХЯ-ны төлөөлөл -СЯ-ны төлөөлөл -АМГТХЭГ-ын дарга	Зардал ҮХЯ, СЯ, АМГТХЭГ хариуцна
		-Хууль тогтоомжийн төслөө ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах -Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх	2008 он	-ҮХЯ-ны төлөөлөл -СЯ-ны төлөөлөл -АМГТХЭГ-ын дарга	Зардал яам, ЗГ хариуцна
7	ОУИТБС-ын тайланг компани, Засгийн газар гаргах маягт, түүний зааврыг эргэж үзэх	-Аудитын зөвлөмж, тайлан гаргасан сургамжийг харгалзан тайлангийн маягт, зааврыг эргэж үзэх	2008 оны 1 дүгээр сард	-Ажлын албаны зохицуулагч -Гишүүд саналаараа	Ажлын алба өдөр тутмын зардал
		-Тайлангийн маягт, зааварт өөрчлөлт оруулах бол ажлын хэсгийн хуралд танилцуулж, Үндэсний зөвлөлийн хурлаар дэмжүүлэх	2008 оны 2 дугаар сарын 15-ны дотор	-Ажлын албаны зохицуулагч -ҮТЕГ-ын дарга -МНБИ-ийн ерөнхийлөгч -ТББ эвсэл	Дахиж хэвлүүлэх бол Ажлын алба хариуцна
8	Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, эсэхийг судлах	-Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд Авилгалтай тэмцэх газраас төлөөлөл оруулах асуудлыг судлах	2008 оны 2-р сард	-Ажлын хэсгийн ахлагч -Ажлын хэсгийн нбд	Зардал ЗГХЭГ хариуцна
		Саналаа Үндэсний зөвлөлийн даргад танилцуулж, шаардлагатай бол шийдвэрлэх	2008 оны 2-р сард	- Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга	Зардал ЗГХЭГ хариуцна
9	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг эрхлэн зохион байгуулж, хариуцах үүрэгтэй бие даасан ажлын алба ажиллах	-Ажлын алба 2 хүнтэйгээр ажиллах	жилдээ	Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга	Жилийн нийт зардал- 46430\$, ХИС
		-Ажлын алба Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт өдөр тутмын дэмжлэг үзүүлэх	жилдээ	Ажлын албаны зохицуулагч	Жилийн төсвөөр
		-Ажлын хэсэг үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж байх	Улирал бүр	Ажлын албаны зохицуулагч	үйл ажиллагааны зардал
		-Итгэлийн сангийн хандивын зарцуулалтад аудит хийлгэх	Жилдээ	Ажлын албаны зохицуулагч	5000 \$ ХИС
10	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хэрэгжилтийн явцын талаархи мэдээллээр хангах	-Санаачлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын явцын талаар ажлын хэсгийн гишүүдэд мэдээлэх	2 сар тутам	Ажлын албаны зохицуулагч Ажлын хэсгийн нбд	Ажлын албаны өдөр тутмын зардлаас
		-Санаачлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын явцын талаар Үндэсний зөвлөлийн гишүүдэд мэдээлэх	3 сар тутам	Үндэсний зөвлөлийн НБД	Ажлын албаны өдөр тутмын зардлаас
Б.Чадавхи бий болгох, бэхжүүлэх талаар					
11	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын үндэсний семинар зохион байгуулах	-Сургалт №2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх арга зам сэдвээр 1 өдрийн зөвлөлгөөн, семинар зохион байгуулах бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Зөвлөлгөөн, семинарт 120 хүн, үүнээс орон нутгаас 30 хүн оролцуулах	2008 оны 3 дугаар сард	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг -Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сан 4796 \$ -Байр зардал ЗГ хариуцна

12	ОУИТБС-ын Засгийн газрын тайлан гаргах байгууллагын удирдлага, ажилтанд зориулсан сургалт	Сургалт №4. -а/Анхны сургалт 80 хүн, орон нутгаас 42	2008 оны 3-р сард	Ажлын алба	-Зардал 3664 \$ ХИС -Байр зардал ЗГ
		-Сургалт №5. б/Хоёрдох сургалт 80 хүн, орон нутгаас 42	2008 3-4-р сард	Ажлын алба	-Зардал 3664 \$ ХИС -Байр зардал ЗГ
		-в/чадавхи бэхжүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлэх	4-р сард	Ажлын алба	Ажлын алба
13	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн удирдлагад зориулсан сургалт	Сургалт №6. -а/Удирдлагад зориулсан сургалт 2007 онд 2-4 удаа, /1 удаа 40 хүн/	2008 3-р сард	Ажлын алба	-5128 \$ ХИС -Байр зардал ЗГ
		Сургалт №8. б/Удирдлагад зориулсан сургалт /орон нутагт зохион байгуулна/	2008 онд 3-4 удаа	Ажлын алба	-3996 \$ ХИС -Байр зардал ЗГ
14	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт	-Сургалт №7. Компанийн санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт 40/160 хүн, /төв, орон нутагт зохион байгуулна/, /1 удаа 40 хүн/	2008 2-3-р сард	Ажлын алба	-5128 \$ ХИС -Байр зардал ЗГ
		Сургалт №1. -Компанийн санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт 80-120 хүн /орон нутагт/ 2 удаа	2008 3-4-р сард	Ажлын алба	-4796 \$ ХИС -Байр зардал ЗГ
15	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид зориулсан зөвлөлгөө өгөх	-Компанийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад биечлэн зөвлөлгөө өгөх -Шаардлагатай бол орон нутагт явж зөвлөлгөө өгөх	2008 3-4-р сард	Ажлын алба Ажлын хэсэг ТББ-ын эвсэл	Ажлын албаны зардал Унааны зардал АМГТХЭГ
16	ОУИТБС-ыг сайтар хэрэгжүүлж байгаа туршлага судлуулах	-Дотоодын компанийг сонгон газар дээр үзүүлэх, сургалтад оролцуулж заах	3-4-р сард	Ажлын алба	-
17	Хэвлэл, мэдээллийн байгууллагын эдийн засгийн тоймч, сурвалжлагч нарт мэдээлэл өгөх	-Мэдээлэл, зөвлөмжөөр хангах -уулзалтад урьж танилцуулга хийх -Үйл ажиллагаандаа оролцуулах	2008 ондоо	Ажлын алба	Ажлын албаны өдөр тутмын зардал
18	Компанийн болон Засгийн газрын тайлан гаргалтын явцад ажиглалт хийх	-Компаниудын тайлан гаргах явцад ажиглалт хийж зөвлөлгөө өгөх -Засгийн газрын тайлан гаргах явцад ажиглалт хийж зөвлөлгөө өгөх	2008 оны 3-5-р сард	Ажлын алба	Ажлын албаны өдөр тутмын зардал
19	“ОУИТБС ба Засаглалыг сайжруулах, төрийн санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх” семинар зохион байгуулах	Сургалт №3. Семинарын бэлтгэл хангах Семинар зохион байгуулах 90 хүн, Санаачлага, хөтөлбөр тус бүрээс 30 хүн, 1 өдөр,	2008 онд	Үндэсний зөвлөл Ажлын алба Сангийн яам ЗГХЭГ, ТАЗ	3222 \$ ХИС /Оролцогч 2 төсөлтэй хамтран/ Байр Засгийн газар
20	ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж байгаа улсад хийх танилцах аялал	Танилцах аялал зохион байгуулах ҮЗ-1 хүн, АХ-1 хүн, АА-1 хүн, ААН-1 хүн, ТББ-1 хүн	2008 онд	Ажлын алба	10.000 \$ ХИС
В. Мэдээлэл түгээх, сурталчилгаа хийх, туршлага судлах талаар /communications/					
21	ОУИТБС-ын талаархи танилцуулга, гарын авлага материалыг англи хэлнээс орчуулан бэлдэж оролцогч компани, төрийн бус байгууллагад тараах	-холбогдох материал олох -Орчуулах -Захиалж хэвлүүлэх	2008 онд	-Ажлын алба	-Зардал 1300 \$ ХИС
		Засгийн газрын байгууллага, компаниуд, төрийн бус байгууллагыг холбогдох электрон мэдээллээр хангах	2007 оноос	Ажлын алба	Ажлын алба
22	Монгол Улс-ОУИТБС вэб сайтаа тогтмол баяжуулж байх	Веб хуудсыг тогтмол баяжуулж байх, үйлчилгээ хийлгэх, хэлэлцүүлэг явуулах	Тогт-мол	-Ажлын алба	640 \$ ХИС

23	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, үр дүнг тусгай төлөвлөгөөний үндсэн дээр тогтмол сурталчлах	-а/ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр TV нэвтрүүлэг зохион байгуулах /сонгон шалгаруулж/	4-5-р сард	-Ажлын алба	-Зардал 11000 \$ ХИС
		-б/өдөр тутмын сонинтой гэрээ байгуулан цуврал нийтлэл гаргах, хэлэлцүүлэг зохион байгуулах	2, 4-р сард	Ажлын алба Зөвлөх	-Зардал 1500 \$ ХИС
		-в/Хэвлэлийн бага хурал зохион байгуулах	4 удаа	ҮЗ, АХ, Ажлын алба	Ажлын алба
		-г/мэдээлэл түгээх бусад арга зам	-	Ажлын алба	Ажлын алба
24	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, шийдвэр, тайлангийн маягт, хамрагдах 3 талт байгууллагын чиг үүрэг зэргийг багтаасан эмхтгэл хэвлүүлэх	-Холбогдох хууль тогтоомж, баримт материалыг түүвэрлэж олшруулах	2008 3-6-р сар	Ажлын алба	Ажлын алба
		Шаардлагатай бол энэ баримт бичгийг 600-1000 хувиар хэвлэж хүргэх	2008 онд	Ажлын алба	-Зардал 1300 \$ ХИС
		Маягт, заавар хэвлүүлэх	2008	Ажлын алба	300 \$ ХИС
		2009 оны Календарь хэвлүүлэх	2008	Ажлын алба	1000 \$ ХИС
25	ОУИТБС-ын хэрэгжилт, үйл ажиллагааны талаар товхимол бэлтгэн хэвлүүлж сурталчлах	Тайлан, мэдээлэл, санхүүгийн тайлан, аудитын дүнг брошюр болгон хэвлэж байх	3-р сард	-Ажлын алба	-Зардал 500 \$ ХИС
26	"ОУИТБС-Монгол Улс" товхимол англи хэлээр цуврал брошюр бэлтгэх	-Төлөвлөгөө гаргаж материал бүрдүүлэх -Орчуулах	12-р сард	Ажлын алба	2000 \$ ХИС

III үе шат Санаачлага хэрэгжүүлэх үйл ажиллагаа

А. Санаачлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

27	Санаачлагын хэрэгжилтэд мониторинг хийх	-Санаачлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, татварын байгууллагад мониторинг хийх -Мониторингийн дүнг гаргах	2008 оны 3-7 дугаар сард	-Ажлын алба -Ажлын хэсэг -ТББ-ын эвсэл	-Үйл ажиллагааны зардал -ТББ эвсэл зардал бусад хандивлагчийн зардал
28	Улсын болон орон нутагт төлсөн албан татвар, төлбөрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн тайланг аж ахуй бүр гаргаж нийтэд мэдээлэх	-Аж ахуйн нэгж бүр маягтын дагуу тайлан гаргах, нийтэд мэдээлэх -Тайлангаа АМГТХЭГ хүргүүлэх, улмаар ажлын албанд хүргүүлэх	2008 оны 3-4 дүгээр сар	-Ажлын хэсэг -АМГТХЭГ	Зардлыг үйлдвэр, аж ахуйн нэгж хариуцна.
29	Улсын болон орон нутгийн төсөвт тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниас хүлээн авсан албан татвар, төлбөрийн Засгийн газрын тайланг Сангийн яам гаргаж нийтэд мэдээлэх	-компаниас улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөрийн Засгийн газрын тайланг маягтын дагуу Сангийн яам гаргаж нийтэд мэдээлэх -Тайлангаа ажлын албанд хүргүүлэх	2008 оны 3-4 дүгээр сард Цаашид жил бүр	Сангийн яам /ҮТЕГ, ГЕГ, орон нутгийн татварын албад, бусад холбогдох байгууллага/	Зардлыг тус тусын төсвөөс хариуцна /4000000₮/
30	Компанийн болон Засгийн газрын тайланг хүлээн авах	-Тайланг 2 талын мэдээллийн эх үүсвэрээс хүлээн авах	2008 оны 3-6 дугаар сард Цаашид жил бүр	Ажлын алба	-

31	Тайланд аудит хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах аудит хийлгэх	-Сонгон шалгаруулах тендер зарлах, Үнэлгээний хороо байгуулж ажиллуулах	Аудит хийлгэхийн өмнө	Ажлын хэсэг Ажлын алба	Ажлын алба
		2006 оны тайланд олон улсын аудит хийлгэх №1	2007 оны 12-2008 оны 1-р сард	Ажлын алба	103000 \$ ХИС
		2007 оны тайланд олон улсын аудит хийлгэх №2	2008 оны 5-7 дугаар сард	Ажлын алба	100000 \$ ХИС
		2006 оны үлдсэн тайланд дотоодын аудит хийлгэх	2008 оны эхний хагаст	Ажлын алба	7300 \$ ХИС
		2007 оны үлдсэн тайланд дотоодын аудит хийлгэх	2008 оны 5-9 дүгээр сард	Ажлын алба	9600 \$ ХИС
		Аудитын дүнг хэлэлцүүлэх	6-8 дугаар сард	Ажлын алба	-
		Тайлан хэвлүүлэх	Тайлангийн дараа	Ажлын алба	500 \$ ХИС
32	ОУИТБС, түүний хэрэгжилтийн талаар санал асуулга явуулах	-Санал асуулга явуулах сэдвийг тодорхойлох -Санал асуулгын хуудас боловсруулах	2008 оны 5-6 -р сард	-Ажлын алба -ТББ-ууд	Ажлын алба
		-Санал асуулга явуулах -Санал асуулгын дүнг үндэслэн үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулах	дүнг үндэслэн	-Ажлын алба -ажлын хэсэг	Ажлын алба
33	Аудитын тайлан, санал зөвлөмж, санал асуулгын дүнгийн дагуу 2009 онд ажиллах төлөвлөгөө боловсруулах	-Санал зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах -Төлөвлөгөөний төслийг ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж хэрэгжүүлэх	2008 оны 12 дугаар сард	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг -Ажлын алба	-
34	ОУИТБС хэрэгжүүлэгч улсуудтай мэдээлэл солилцох	Мэдээлэл солилцох Шуудан холбоо, e-mail	тогтмол	Ажлын хэсэг	Ажлын алба
Б. ОУИТБС-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, тогтворжуулах нөхцлийг бүрдүүлэх					
35	2009 оны Улсын төсөвт ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, олон улсын баталгаажуулалтын зардлыг тусгах	-Улсын төсөвт тусгах зардлын тооцоо, үндэслэлийг боловсруулах -Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулах -Үндэсний зөвлөлөөс Сангийн яаманд санал болгох	2008 оны 4-6 дугаар сард	-Ажлын алба -Ажлын хэсэг -Үндэсний зөвлөл	-2009 оны улсын төсөвт 40 сая төгрөг
36	ОУИТБС-ыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хандивын санал бэлтгэх	-Ажлын төлөвлөгөө төсөл, хандив авах төсөл боловсруулах -Төслүүдээ ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулж хандивлагч нарт санал тавих	2008 оны 6-8-р сард	-Ажлын алба	Хандивлагчдын итгэлийн сан
37	ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд хандивлагч компанитай болох санал боловсруулах	-Төсөл бичиж хүсэлт тавих -Зохих журмын дагуу тусламж авч, үр дүнг мэдээлэх	2008 он 6-8-р сар	-Ажлын алба -УУА	Бусад хандивлагчид

В. Баталгаажуулах чиглэлээр					
38	Олон улсын баталгаажуулалтад бэлтгэх	-Баталгаажуулалтын аргачлалын дагуу бэлтгэл хангах	2008 11-12-р сард	-ҮЗ, Ажлын хэсэг -ТББ эвсэл, компаниуд	Ажлын алба
		-Зохих журмын дагуу дотоодод баталгаажуулалт хийх	- " -	- " -	- " -
39	Олон улсын баталгаажуулалтад хамрагдахыг хүсэх	-Баталгаажуулалтын талаар олон улсын байгууллагаас лавлагаа авах -Баталгаажуулалтад хамрагдах хүсэлт олон улсын байгууллагад тавих, сонгох	2008 оны 9-10-р сард 2008 оны 12-р сард	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг -Ажлын алба	Ажлын алба
		Баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх	- " -	- " -	Зардал 60 сая төгрөгийг 2009 оны улсын төсөвт

III. Хүлээгдэж байгаа үр дүн: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлж, олборлох үйлдвэрлэл эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч компани улсын болон орон нутагт төлсөн албан татвар, төлбөрөө, Засгийн газар компаниас хүлээн авсан албан татвар, төлбөрийг ил тод тайлагнан нийтэд мэдээлж зөрөөтэй байдлыг аудитаар тодорхойлж хэвшин авилгалаас урьдчилан сэргийлэх орчинг бүрдүүлж, уул уурхайн салбарын орлогын менежментийг сайжруулна.

- о О о -